

МОНГОЛ УЛС  
САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ  
ТОГТООЛ

2007 оны 8 дугаар  
сарын 17-ны өдөр

Дугаар 122

Улаанбаатар хот

Банк бус санхүүгийн байгууллагаас  
төвлөрүүлэх зохицуулалтын үйлчилгээний  
хөлсний хэмжээг шинэчлэн тогтоох тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6.1.5 дахь заалт,  
Санхүүгийн зохицуулах хорооны дүрмийн 5.3-т заасныг тус тус үндэслэн ТОГТООХ НЬ:

1. Банк бус санхүүгийн байгууллагаас төвлөрүүлэх зохицуулалтын үйлчилгээний хөлсний хэмжээг 1 дүгээр хавсралтаар, хөлсний хэмжээг тооцох аргачлалыг 2 дугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Банк бус санхүүгийн байгууллагаас 2006 онд төлөх зохицуулалтын үйлчилгээний хөлсийг Улаанбаатар хотод үйл ажиллагаа явуулахаар тусгай зөвшөөрөл авсан байгууллагаас 500 000 төгрөг, Орхон аймгийн Баян-Өндөр сум, Дархан-Уул аймгийн Дархан суманд үйл ажиллагаа явуулахаар тусгай зөвшөөрөл авсан байгууллагаас 250 000 төгрөг, бусад аймагт үйл ажиллагаа явуулахаар тусгай зөвшөөрөл авсан байгууллагаас 50 000 төгрөгөөр тооцож төвлөрүүлэхийг Ажлын алба /О.Ганбат/-нд даалгасугай.

3. Энэ тогтоол батлагдсантай холбогдуулан Хорооны 2006 оны 8 дугаар сарын 21-ний өдрийн 33 дугаар тогтоолын Банк бус санхүүгийн үйл ажиллагаа эрхлэх байгууллагаас төвлөрүүлэх зохицуулалтын үйлчилгээний төрөл, хөлсний хэмжээг тогтоосон 1 дүгээр хавсралт болон 2006 оны “Аргачлал батлах тухай” 37 дугаар тогтоолын хавсралтын банк бус санхүүгийн байгууллагын зохицуулалтын үйлчилгээний хөлсийг тооцоолох аргачлалын тухай 1 дэх хэсгийг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

4. Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж, нийтэд сурталчлан ажиллахыг Ажлын алба /О.Ганбат/-нд даалгасугай

ДАРГА

Д.БАЯРСАЙХАН

БАНК БУС САНХҮҮГИЙН БАЙГУУЛЛАГААС ТӨВЛӨРҮҮЛЭХ  
ЗОХИЦУУЛАЛТЫН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ХӨЛСНИЙ ХЭМЖЭЭ

Нэг. Жил бүр төвлөрүүлэх

№	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТӨРӨЛ	ДҮРМИЙН САНГИЙН ХЭМЖЭЭ /ангиллаар/						
		≤ 50 000 000	50 000 001- 200 000 000	≤ 100 000 000	100 000 001- 200 000 000	200 000 001- 400 000 000	400 000 001- 800 000 000	800 000 001≤
1.1.	Зээлийн үйл ажиллагаа	-	-	100.0	150.0	300.0	350.0	400.0
1.2	Факторингийн үйлчилгээ	-	-	50.0	100.0	150.0	200.0	250.0
1.3	Төлбөрийн баталгаа гаргах	-	-	50.0	100.0	150.0	200.0	250.0
1.4	Гадаад валютын арилжаа	100.0	150.0	-	-	250.0	300.0	350.0
1.5	Хөрөнгө оруулалт, санхүүгийн чиглэлээр зөвлөгөө, мэдээлэл өгөх	-	-	50.0	100.0	200.0	250.0	300.0
1.6	Төлбөр тооцооны хэрэгсэл гаргах	-	-	-	-	-	1000.0	1000.0
1.7	Цахим төлбөр тооцоо, мөнгөн гуйвуулгын үйлчилгээ	-	-	-	-	-	1000.0	1000.0
1.8	Итгэлцлийн үйлчилгээ	-	-	-	-	-	1000.0	1000.0
1.9	Богино хугацаат санхүүгийн хэрэгсэлд хөрөнгө оруулалт хийх	-	-	-	-	-	1000.0	1000.0
	<b>БАЙРШИЛ</b>	<b>БАЙРШЛААС ХАМААРЧ ТӨВЛӨРҮҮЛЭХ</b>						

		ХӨЛСНИЙ ХЭМЖЭЭ /мянган төгрөгөөр/
1.10	Улаанбаатар хот	500.0
1.11	Орхон аймгийн Баян-Өндөр сум, Дархан-Уул аймгийн Дархан сум	250.0
1.12	Энэ хавсралтын 1.10, 1.11-д зааснаас бусад аймагт	50.0

Хоёр. Тухай бүр төвлөрүүлэх

ЗОХИЦУУЛАЛТЫН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ТӨРӨЛ	ТӨВЛӨРҮҮЛЭХ ХӨЛСНИЙ ХЭМЖЭЭ /төгрөгөөр/
1. Салбар байгуулах зөвшөөрөл	
1.1. Улаанбаатар хотод	1.1. 200 000
1.2. Улаанбаатар хотоос бусад орон нутагт	1.2. 20 000
2. Төлөөлөгчийн газар байгуулах	50 000
3. Оноосон нэр өөрчлөх	2 000 000
4. Үрэгдүүлж, гэмтээсэн гэрчилгээг солих, нөхөн олгох	20 0000

Тайлбар: Улаанбаатараас бусад хот, орон нутагт байгуулагдсан боловч салбараа Улаанбаатар хотод нээн үйл ажиллагаагаа явуулж байгаа банк бус санхүүгийн байгууллагын хувьд зохицуулалтын үйлчилгээний хөлсийг Улаанбаатар хотод байршилтай банк бус санхүүгийн байгууллагын жишгээр тооцож төвлөрүүлнэ.

-- ооОоо --